

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго: Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хүн амыг олон улсын стандартын шаардлагад нийцсэн чанартай, аюулгүй, эмчилгээний өндөр идэвхтэй эм, эмнэлгийн хэрэгслээр хангаж, нотолгоонд суурилсан хараат бус мэдээллийг баталгаажуулан түгээж, үйл ажиллагаандаа дэвшилтэт техник технологи ашиглан олон талт, тогтвортой хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ.							
Зорилт 1. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангаж, төрөөс баримтах бодлогыг хэрэгжүүлнэ.							
1.	БСТ 1.1, 5.1, 5.2, 7.2, 8.1, 11.1, 11.5 Арга хэмжээ 1.1. Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хяналт, зохицуулалттай холбоотой эрх зүйн орчныг сайжруулна.	300 сая (улсын төсөв) 50 сая (улсын төсөв)	Хууль, журмын төсөлд хүргүүлсэн саналын тоо Батлагдсан журам Батлуулсан САЗ-ын тоо	Хууль, журмын төсөлд 2023 онд нийт 20 санал хүргүүлсэн. Агентлагийн даргаар 2023 онд нийт 8 журам, 190 САЗ батлуулсан.	Хууль, журманд 10-аас дээш удаа санал хүргүүлж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа журам, САЗ-ыг шинээр батлагдсан хууль эрх зүйн зохицуулалтыг тусган шинэчлэн боловсруулж, агентлагийн даргын тушаалаар 4 журам, 25 САЗ батлуулсан байна.	Батлагдсан хууль-1, журам-6, хүргүүлсэн саналын тоо-200. Үүнд: - “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар батлуулж, бусад дагалдах хууль, журманд 200 гаруй саналыг холбогдох газруудад хүргүүлсэн. - Мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төсөлд нийт 60 заалт бүхий саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 01/862 тоот албан бичгээр хүргүүлсэн. - Монгол Улсын Засгийн газрын 42 дугаар тогтоолоор “Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам” 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр батлагдсан. Батлагдсан журмын тоо-5, журманд хүргүүлсэн саналыг тоо-1	100

					- Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын мэдүүлэг олгох журмыг батлуулсан. - Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дэргэдэх эмийн улсын нөөцийн агуулахад олон улсын хавдрын эм хадгалах журамд нийцүүлэн “Хүүхдийн хорт хавдарын эмийн хангамж, хүртээмжийг сайжруулах дэлхийн платформ” санаачлагын хүрээнд: 1. Эм, барааны зохистой нөөц бүрдүүлэлт, хяналтын болон нөөцийн удирдлагын системийн журам 2. Температурын тусгай нөхцөлтэй эм бараа хадгалах хэрэгслийн ажиллагаа доголдоход яаралтай хэрэгжүүлэх журам 3. Хүйтэн хэлхээний температурыг бүртгэх, хянах стандарт ажлын журам 4. Агуулахын температур, чийгийн хэмжээг бүртгэх, хянах стандарт ажлын журам гэсэн 4 журмыг боловсруулж, батлуулсан - “Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх журмын төсөл”-д оруулах саналыг Эрүүл мэндийн яаманд 01/926 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Батлуулсан САЗ-ын тоо-39 - Эмийн бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа 14 САЗ-ыг агентлагийн даргын 2023 оны А/233 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 7 дугаар ... тушаалд орсон өөрчлөлтийг тусган шинэчлэн боловсруулж, эмийн бүртгэлийн үйл ажиллагааны процессын зураглалыг шинэчлэн гаргаж, батлуулсан. - Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбоотой 2 САЗ батлуулсан. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ гээгдүүлсэн үйл ажиллагааны САЗ, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах САЗ-т Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/383, А/402 тушаалыг	
--	--	--	--	--	--	--

						үндэслэн нийт 3 заалт, 1 бүлэг өөрчлөлтийг нэмж батлуулсан. - Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хэрэглэх САЗ - Биобэлдмэлийн аюулгүй байдлыг хангах, оролцогч талуудтай мэдээлэл солилцох САЗ - Эм шинжлэх лабораторид 2024 онд худалдан авалт хийсэн 18 багажны ажиллуулах зааврыг орчуулж, САЗ-ыг боловсруулж, батлуулсан. - Хуурамч, стандартын бус эмийг илрүүлэх, тандалт судалгаа хийх САЗ-ыг боловсруулж, батлуулсан. - Эмийн сонголт-Зайлшгүй шаардлагатай эмийн сонголт хийх САЗ-ыг шинэчлэн батлуулсан.	
2.	Арга хэмжээ 1.2 Улсын хилээр төрийн хяналт дор нэвтрүүлэх бараа бүтээгдэхүүний журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулна.		Хүргүүлсэн саналын тоо	-	Тус журамд оруулах саналыг боловсруулж, ЭМЯ-нд хүргүүлсэн байна.	Хүргүүлсэн санал-2. Үүнд: 1.Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Гаалийн ерөнхий газарт 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 01/638 дугаар албан бичиг хүргүүлж, эмчилгээ, урьдчилан сэргийлэх зориулалттай эд эрхтэн, донорын цус, бичил биетний өсгөвөр зэрэг барааны ангиллын код өөрчлөгдсөн эсэх талаар тодруулга авсан. Гаалийн ерөнхий газраас БТКУС-д үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтыг ГЕГ-ын даргын 2022 оны А/145 дугаар тушаалаар шинэчилсэн бөгөөд эмчилгээ, урьдчилан сэргийлэх зориулалттай эд эрхтэн, донорын цус, бичил биетний өсгөвөр зэрэг барааны зарим ангиллын кодыг хүчингүй болгосон болохыг мэдэгдэж жагсаалтыг ирүүлсэн. Уг өөрчлөлтийг тусган улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодолсон	100

						барааны жагсаалт, журманд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Эрүүл яаманд хүргүүлсэн.	
3.	БСТ 4.3 Арга хэмжээ 1.3 Анагаах ухааны Ёс зүйн хяналтын хорооны үйл ажиллагаатай уялдуулж, эмийн эмнэлзүйн туршилтын журмын төслийг боловсруулна.	52 сая (улсын төсөв) 50 сая (улсын төсөв)	Хүргүүлсэн журмын төсөл	-	Журмын төслийг боловсруулж, ЭМЯ-нд хүргүүлсэн байна.	Агентлагийн даргын 2024 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн А/117 дугаар тушаалаар “Шинэ эмийн эмнэлзүйн туршилт явуулах журам”-ыг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, ажлын төлөвлөгөө, удирдамжийн дагуу шинэ эмийн эмнэлзүйн туршилтын журмын төслийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн.	100
4.	Арга хэмжээ 1.4 Монгол улсад бүртгэх БИБ-ний тунгийн хязгаар, нэр төрлийн ангилалын жагсаалтыг боловсруулж, батлуулна.	3 сая төгрөг (улсын төсөв, төсөл, хөтөлбөр)	Батлагдсан жагсаалт	-	Жагсаалтын төслийг ДЗХ-аар хэлэлцүүлж, агентлагийн даргын тушаалаар батлуулсан байна.	Монгол улсад бүртгэх Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний тунгийн хязгаар, нэр төрлийн ангиллын жагсаалтыг боловсруулж, жагсаалтын төслийг байгууллагын цахим хуудсанд 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр байршуулж санал авсан. Биологийн идэвхт бүтээгдэхүүний салбар зөвлөлийн гишүүд, орон тооны бус шинжээчид болон байгууллага, аж, ахуйн нэгжээс ирүүлсэн саналыг тусгаж, 2062 нэрийн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний жагсаалтыг үүсгэсэн боловч хууль эрх зүйн баримт бичигт Монгол улсад бүртгэх эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний тунгийн хязгаар, нэр төрлийн ангиллын жагсаалтын талаар тусгагдаагүй тул “Эм, эмийн түүхий эд, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний журам” шинэчлэн батласны дараа батлуулахаар хүлээгдэж байна.	90
5.	БСТ 5.4 Арга хэмжээ 1.5 Бүртгэлийн шинжээчийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулна.	3 сая төгрөг (улсын төсөв, төсөл, хөтөлбөр)	Шинэчлэн батлагдсан журам Шинэчлэгдсэн үнэлгээний хуудас	Агентлагийн даргын 2023 оны А/233 дугаар тушаалаар батлагдсан журмыг	Бүртгэлийн шинжээч ажиллуулах журмыг ДЭМБ-ын удирдамжтай уялдуулж, шинэчлэн батлуулсан байна.	Шинэчлэн батлагдсан “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-тай нийцүүлэн “Бүртгэлийн шинжээч ажиллуулах журам”-ыг шинэчлэн боловсруулж, байгууллагын цахим хуудсанд 2024 оны 9 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн 30 хоног байршуулж, санал авч тусган журамд дараах заалуудын шинээр тусгасан. Үүнд:	70

				хэрэгжүүлэн ажиллаж байна.		- Бүртгэлийн шинжээчид “E-business” платформоор бүртгэлийн материалыг цахимаар хүлээн авч, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл, болон бүртгэлийн материалын дүгнэлтээ цахимаар оруулах талаар - Лабораторийн оношилгооны хэрэгслийн тухайд бусад улсад зөвшөөрөгдсөн байдал, Үндэсний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрөөр үнэлэгдэж, зөвшөөрөгдсөн арга барилаар үнэлэгдсэн эсэх, тогтвортой байдлын судалгаа - Биоэквивалентын судалгааны талаарх ДЭМБ-ын удирдамжийн мэдээлэл - Шинжээчийн эрх үүрэг, гэрээг цуцлах зохицуулалтад нэмэлт оруулсан. Шинэчлэгдсэн үнэлгээний хуудас-1 - Түүхий эд, уламжлалт эмийн шалгуур хуудсыг шинэчилсэн.	
6.	Арга хэмжээ 1.6 Эм, эмийн түүхий эд, БИБ-ний бүртгэлийн журмыг шинэчлэн боловсруулсан төсөлд нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.	3 сая төгрөг (улсын төсө төсөл, хөтөлбөр)	Үнэлгээний тайлан	Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/295 дугаар тушаалыг хэрэгжүүлж байна.	Нөхцөл байдлын үнэлгээ хийж, тайланг ДЗХ-аар хэлэлцүүлж, ЭМЯ-нд хүргүүлсэн байна.	“Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэлийн журам”-ыг шинэчлэн боловсруулж, 2024 оны 8 дугаар сарын 17, 10 дугаар сарын 30-ны өдөр тус бүр 30 хоногийн хугацаатай байгууллагын цахим хуудсанд байршуулж, ирүүлсэн саналыг тусган журмын төслийг боловсруулсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалаар батлагдсан “Захиргааны хэм, хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу журмыг төсөлд үнэлгээ хийж, төслийг Эрүүл мэндийн яаманд 2024 оны 10 сарын 30-ны өдрийн 01/1792, 11 сарын 13-ны өдрийн 01/1955 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.	100
7.	БСТ 1.2 Арга хэмжээ 1.7		Хэрэгжилтийн хувь	Байгууллагын дунд хугацааны	Тус төлөвлөгөөний 2024 онд хэрэгжүүлэх	2023-2026 онд хэрэгжүүлэх Байгууллагын хөгжлийн төлөвлөгөө нь 9 чиглэлийн хүрээнд нийт 87 ажлыг хэрэгжүүлэхээр багтаасан. 2024	90

	Байгууллагын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.			хөгжлийн төлөвлөгөө	арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.	онд эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын 9 чиглэлээр 53 шалгуур үзүүлэлтийн дагуу 66 арга хэмжээ тусгагдаж, тайланг 6 газар, 2 хэлтэс болон Эм шинжлэх лаборатори буюу нийт 9 нэгжээс хүлээн авч нэгтгэсэн байна.	
8.	ЗГҮАХ 2.1.8.3 Арга хэмжээ 1.8 Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө (2022-2025)-ний хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Батлагдсан төлөвлөгөө	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/450 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/450 дугаар тушаалаар “Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2022-2025 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 3 зорилтын хүрээнд 19 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс 90-100 хувийн хэрэгжилттэй-9 арга хэмжээ, 70-90 хувийн хэрэгжилттэй-4 арга хэмжээ, 30-50 хувийн хэрэгжилттэй-6 арга хэмжээ байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хавсралт-1	70
9.	БСТ 1.3 Арга хэмжээ 1.9 Бүсийн эсвэл бусад орны эмийн зохицуулалтын байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлж, зохицуулалтын шийдвэр гаргалтад итгэлцлийн зохистой дадлыг хэрэгжүүлнэ.	-	Хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	ДЭМБ-ын итгэлцлийн зохистой дадлын удирдамж (GRP) ДЭМБ-ын техникийн дэмжлэгтэй 9 төсөл хэрэгжүүлсэн.	ДЭМБ-ын итгэлцлийн зохистой дадлын удирдамжийг хэрэгжүүлдэг бусад улсын эмийн зохицуулалтын байгууллагын судалгаа хийж, удирдамжийг орчуулж, гарын авлага гаргаж, олон улсын 1 байгууллагатай хамтын ажиллагаа эхлүүлсэн байна.	1. Гадаад улсын ижил төстэй байгууллагын үйл ажиллагаанаас туршлага судлах, хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор Бүгд Найрамдах Польш улс, Оросын холбооны улс, Бүгд Найрамдах Солонгос улс, Япон улсуудын зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагааг судалж, Бүгд Найрамдах Польш улсын элчин сайдын яам, Америкын нэгдсэн улсын элчин сайдын яам болон тус улсуудын гадаад явдлын яамны ази номхон далайн бүсийг хариуцсан хэлтсийн даргатай уулзалт зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааг хэлэлцсэн. 2. ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч Сокорро Эскаланте болон холбогдох хүмүүстэй уулзалт зохион байгуулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцож, хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл гаргасан. 3. ДЭМБ-ын дэлхийн нийтийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хамтарч олон улсын жишигт лабораторийн	70

						тухай сургалт, уулзалт, семинар зохион байгуулсан. ДЭМБ-ын Ази номхон далайн бүсийг хариуцсан газартай холбогдож, эмийн зохицуулалтын сайн дадал болон хангамж түгээлтийн сайн дадалын хүрээнд нийт 3 өдрийн вебинар зохион байгуулсан.	
10.	БСТ 1.4 Арга хэмжээ 1.10 Олон улсын удирдамж, стандартын дагуу эмийн зохицуулалтын байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ.	25 сая (улсын төсөв)	Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө Сургалтад хамрагдсан хүний тоо Гарын авлага	ДЭМБ-ын батлагдсан чанарын гарын авлага Эмийн зохицуулалтын байгууллагын чанарын удирдлагын тогтолцооны гадаад сургалтад 2 албан хаагч хамрагдсан.	Эмийн зохицуулалтын байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулж, гарын авлага боловсруулан хүний нөөцөө чадавхжуулсан байна.	Эмийн зохицуулалтын байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх батлсагдсан төлөвлөгөөний хүрээнд Эм зүйн мэргэжлээр төгсөгчдийн холбоо НҮТББ-тай хамтран Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үйл ажиллагаанд ДЭМБ-ын “Үндэсний зохицуулалтын байгууллагад чанарын менежментийг хэрэгжүүлэх шаардлага” удирдамж болон Олон улсын ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах, хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор “Чанарын менежментийн тогтолцоо, ач холбогдол” сургалтыг байгууллагын нийт албан хаагчдад 2024 оны 3 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Мөн стандартыг нэвтрүүлэхэд зөвлөх үйлчилгээ авах зарыг байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулж, 1 байгууллагаас үнийн санал ирүүлсэн. Байгууллагын 2025 оны төсвийн төсөөлөлд чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэхэд шаардлагатай төсвийн төсөөллийг оруулсан.	50
11.	БСТ 1.5 Арга хэмжээ 1.11 Эм зүйн салбарын сайн засаглал (Эм зүйн салбарын үзүүлэлт, зохицуулалтын үйл ажиллагааны мэдээлэл, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн хувь)-ыг	-	Эм зүйн салбарын үзүүлэлт Сэтгэл ханамжийн судалгааны дүн Өргөдөл, гомдол, санал, хүсэлт	Эм зүйн салбарын үзүүлэлт 2022 он сэтгүүл Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн.	Эм зүйн салбарын сайн засаглалын бэхжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хэсэг байгуулсан байна. Сэтгэл ханамжийн судалгаа хийж, 3.9-ээс үнэлгээ авсан байна.	“Эм зүйн үзүүлэлт-2023” оны сэтгүүлийг 2 бүлгийн 62 үзүүлэлтээр 300 ширхэгийг хэвлүүлсэн. Эм зүйн салбарын үндсэн үзүүлэлтийг эмхэтгэн гаргах нь бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч болон бусад хэрэглэгчид эрүүл мэндийн салбарын ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг. Хүн ам зүйн болон эрүүл мэндийн үзүүлэлт, эм зүйн салбарын ерөнхий үзүүлэлт, хүний нөөцийн үзүүлэлт, эдийн засгийн үзүүлэлт, эмийн зохицуулалт, эмнэлгийн тоног	100

	бэхжүүлж, ил тод байдлыг хангана.			2023 оны сэтгэл ханамжийн судалгааны дүн 3.9 үнэлэгдсэн.		төхөөрөмжийн шалгалт тохируулга үйл ажиллагааны агуулгыг багтаасан. Сэтгүүл гаргах ажлын хэсгийг 2024 оны А/34 дугаар тушаалаар батлуулж, тоон мэдээлэл цуглуулахаар 15 байгууллагад (21 аймгийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар ЭМЗУИС, Этүгэн Их Сургууль, ШАУИС, МҮИС, Хүрээ Мэдээлэл Холбоо, Технологийн Дээд Сургууль, Энэрэл Дээд Сургууль, Оточ Манранба Дээд Сургууль, ШУТИС-Эрчим Хүчний Сургууль, АШУҮИС-Ийн Эмзүйн Сургууль, Говь-Алтай, Дархан, Дорноговь Аймгийн Анагаах Ухааны Коллеж) хүргүүлж, 14 байгууллагаас албан бичгээр ирүүлсэн тоон мэдээллийг 2023 оны үзүүлэлтийн нэгтгэлд оруулж, Сэлэнгэ пресс ХХК-тай ажил гүйцэтгэх ЭЭХХЗГ-03/45 дугаартай гэрээ байгуулж, хэвлүүлсэн. Сэтгэл ханамжийн судалгаа Байгууллагын үйл ажиллагааны талаар харилцагч байгууллагуудаас цахимаар сэтгэл ханамжийн судалгаа авсан. Тус судалгаа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 1313.mn статистик мэдээллийн санд бүртгэгддэг бөгөөд судалгаанд 222 хэрэглэгч хамрагдсан байна. Судалгаанд агентлагийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг авахад нийт оролцогчийн 55,4 хувь хялбар, 44,6 хувь хүндрэлтэй гэж хариулсан ба нийт хэрэглэгчийн 21,8 хувь эмийн бүртгэлийн асуудлаар, 14,3 хувь эмийн аюулгүй байдал, 13,1 хувь лиценз, тусгай зөвшөөрөл, 7,4 хувь эмийн чанар, 6,9 хувь эм хангамж, 4,6 хувь лаборатори, 1,7 хувь тендер, 30,3 хувь бусад асуудлаар хандсан байна. Мөн байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийх хөндлөнгийн байгууллага сонгон шалгаруулах ажлын комисс гарч байгууллагын цахим хуудсанд зар
--	-----------------------------------	--	--	--	--	--

						байршуулж, “Нэг бүс, нэг зам” олон улсын хөгжлийн судалгааны академи хэрэглэгчийн үнэлгээ хийсэн. Үнэлгээний тайланг 2024 оны 11 сарын 28-ны өдөр хүлээн авч Эрүүл мэндийн хөгжлийн төвд 12 сарын 15-ны өдрийн 01/2162 албан бичгээр хүргүүлсэн. Байгууллагад 2024 онд нийт 748 өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс: Шийдвэрлэлтээр авч үзвэл: 1.Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн-649. Шийдвэрлэлт 86,7 хувь. 2.Хугацаа хоцорч шийдвэрлэсэн-99. Үүнд: - Эмийн бүртгэлийн хэлтэс-42 - Захиргаа, удирдлагын газар-35 - Эм хангамжийн газар-11 - Чанарын хяналтын газар-6 - Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газар-1 - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар-1 - Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар-1 - Эм шинжлэх лаборатори-1 - Ёс зүйн дэд хороо-1 Хүлээн авсан байдлаар авч үзвэл: - Иргэд олон нийттэй харилцах 1111 төвөөр дамжуулан ирсэн-410 - Иргэнээс ирсэн-155 - Албан хаагчдаас ирүүлсэн-183 Ирүүлсэн хэлбэрээр авч үзвэл: - Гомдол-298 - Хүсэлт-356 - Санал-93 - Мэдээлэл-1 Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээллийг улирал бүр байгууллагын цахим хуудасны үйл ажиллагаа цэсийн “Өргөдөл гомдол” хэсэгт нийтэлж, иргэд олон нийтэд ил тод мэдээлсэн.	
12.	Арга хэмжээ 1.12 Байгууллагын үйл ажиллагаанд	-	Батлагдсан төлөвлөгөө	Байгууллагын үйл ажилгаанд дотоод хяналт	Дотоод хяналт шалгалт, үнэлгээний үр дүнг удирдлагад	Байгууллагын үйл ажиллагаанд 2024 онд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын төлөвлөгөөг 01 дүгээр сарын 28-ны өдөр	100

	төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ зохион байгуулна.		Илэрсэн зөрчлийг арилгасан арга хэмжээний тоо Тайлан	шалгалт, үнэлгээ 8 удаа хийсэн.	танилцуулж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулах зөвлөмжийг хүргүүлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	агентлагийн даргаар батлуулж, жилийн эцсийн байдлаар төлөвлөөт 8 дотоод хяналт, төлөвлөгөөт бус 2 дотоод хяналт хийсэн байна. Үүнд: 2023 онд гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт шалгалт хийх, удирдамж, төлөвлөгөөг 3 дугаар сарын 20- ны өдөр батлуулж, 3 дугаар сарын 21-ний өдрөөс 4 дүгээр сарын 04-ний өдрийн хугацаанд хэрэгжүүлж, 8 зөвлөмж болон тайланг төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, удирдлагуудад танилцуулсан. Төсөл хөтөлбөр (төсөв)-ийн хөрөнгийг зориулалтын дагуу бусаар зарцуулахгүй байх, уг хөрөнгөөс байгууллагын албан хаагчдад болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд урамшуулал олгож байгааг таслан зогсоох, 2022-2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд дотоод шалгалт хийж, үр дүнг холбогдох албан тушаалтнуудад танилцуулсан. - Эм шинжлэх лабораторийн “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих шаардлага MNS/ISO IEC 17025:2018 стандартын “Нөөцөд тавих шаардлага”, “Үйл явцад гарах шаардлага”, “Менежментийн тогтолцоонд тавих шаардлага”-уудын хүрээнд дагалдан гарсан журам, гарын авлага болон агентлагийн даргын 2022 онд А/184 дугаар тушаалаар баталсан “Бүтээгдэхүүний дээж шинжлэх журам”-ын хэрэгжилтэд дотоод хяналт шалгалт хийх удирдамж, төлөвлөгөөг 3 дугаар сарын 27-ны өдөр батлуулж, 4 дүгээр сарын 21-ний өдрөөс 4 дүгээр сарын 04-ний өдрийн хугацаанд хэрэгжүүлж, баримт бичгийн хэрэгжилт болон шинжээчдийн үйл ажиллагаанд босоо мөшгих хяналтад нийт 25 үл тохирол илэрч 22 арга хэмжээг	
--	--	--	--	--	--	--	--

						сайжруулах боломжийг гарган тайланг удирдлагад танилцуулан 11 дүгээр сарын 20-ны өдөр зөвлөмжийн биелэлтийг авсан. 3. Агентлагт ирсэн гомдлын дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гүйцэтгэж, танилцуулгыг 01/102 дугаар албан бичгээр Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. 4. Авлигатай тэмцэх газраас 2023 онд тус газарт хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж ирүүлсэний дагуу зөвлөмжид дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэн Авлигийн эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-т заасны дагуу биелэлт үр дүнгийн талаарх танилцуулгыг 2024 оны 3 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлсэн. 5. Тус газрын албан тушаалтнуудтай холбоотой 2 удаа төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гүйцэтгэж, танилцуулгыг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлсэн. 6. Тус газрын албан тушаалтнууд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа болон 2024 онд илүү цагаар ажилласан албан тушаалтнуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж илэрсэн асуудлыг “Даргын зөвлөл”-хурлаар 9 дүгээр сарын 05-ны өдөр танилцуулсан. Мөн зөрчлийг арилгах хугацаатай үүрэг өгсөний дагуу холбогдох албан тушаалтнуудаас биелэлтийг гаргуулж, “Даргын зөвлөл”-ийн хурлаар танилцуулсан. 7. Авлигатай тэмцэх газраас 2023 онд тус газарт хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж ирүүлсэний дагуу зөвлөмжид дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэн Авлигийн эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-т заасны дагуу нэмэлт	
--	--	--	--	--	--	--	--

						ажлын биелэлтийг 10 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлсэн. 8. Эмнэлгийн тоног төхөөрмжийн газарт 2023, 2024 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх удирдамж, төлөвлөгөөг 10 дугаар сарын 18-ны өдөр батлуулж, 10 дугаар сарын 21-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийн хушацаанд хэрэгжүүлж, баримт бичгийн хэрэгжилт болон мэргэжилтнүүдийн үйл ажиллагаанд нийт 22 үл тохирол илэрч 18 залруулах ажиллагаа, 4 сайжруулах боломжийг гарган тайланг удирдлагад танилцуулж, 12 дугаар сарын 16-ны өдөр зөвлөмжийн хэрэгжилтийг авахаар ажиллаж байна.	
13.	ЗГҮАХ 2.1.8 БСТ 1.6 Арга хэмжээ 1.13 Хүний нөөцийн хөгжлийн тогтвортой байдлыг хангана.	-	Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь Зохицуулалтын үйл ажиллагааны чиглэл бүрийг тусгасан сургалтын нэгдсэн төлөвлөгөө Тайлан	Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг 94 хувьтай хэрэгжүүлсэн. Эм зүйн салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалтын төлөвлөгөөг 90 хувьтай хэрэгжүүлсэн.	Албан хаагчдын нийгмийн баталгаа хангах төлөвлөгөө боловсруулж, 94 хувиас дээш хэрэгжүүлсэн байна. Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг 95 хувиас дээш хэрэгжүүлсэн байна.	1. “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 5 жилийн хөтөлбөр”-ийг агентлагийн даргын 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн “Журам батлах тухай” А/66 дугаар тушаалын хавсралтаар баталсан. Энэхүү хөтөлбөрийн дагуу төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 01 дүгээр сарын 29-ний өдөр батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: - 5 албан хаагчид шинээр зэрэг дэв олгуулах, зэрэг дэвийг ахиулах саналыг албан бичгээр холбогдох тушаал шийдвэрүүд, өмнөх оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээний хуудас зэргийг хавсаргаж, Эрүүл мэндийн яаманд 01 дүгээр сарын 13-ны өдөр 01/147 дугаар албан бичгээр хүргүүлж, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 02 дугаар сарын 13-ны өдрийн “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах тухай” 04 дүгээр тогтоолоор шинээр 4 албан хаагчид зэрэг дэв	100

						олгож, 1 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулсан. - Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан “Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн байр сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд газрын албан хаагчдын онцлогт тохирсон төсөл, хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэх “Хүсэлт гаргах тухай” 01/729 дугаар албан бичиг Нийслэлийн орон сууцны корпорацид 2024 оны 5 дугаар сарын 09-ний өдөр хүргүүлсэн. - 2024 оны А/85 дугаар тушаалаар албан хаагчдын хоол, унааны зардлыг шинэчлэн олгосон. Мөн Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд байгууллагын эцэг эхийн зөвлөлтэй хамтран “Миний аав ээжийн байр” үйл ажиллагаа зохион байгуулсан. 2. Төрийн албан хаагчийг чадавхжуулах 2024 оны сургалтын төлөвлөгөөг байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, Эм зүйн салбарын мэргэжилтнүүдэд зориулсан гадаад сургалт, Төрийн албан хаагчдад зориулсан дотоод сургалтын төлөвлөгөө 3 дугаар сарын 19-ний өдөр батлуулсан. Эм зүйн салбарын мэргэжилтнүүдэд зориулсан гадаад сургалтын төлөвлөгөөнд: 1. Орон нутгийн салбарын мэргэжилтнийг чадавхжуулах бүсчилсэн сургалт 2. Нийслэлд ажиллаж буй салбарын мэргэжилтнийг чадавхжуулах сургалт 3. Лабораторийн шинжилгээнд дадлагажуулах сургалт гэсэн 3 зорилтын хүрээнд 13 сургалт	
--	--	--	--	--	--	--	--

						төлөвлөсөн. Үүнээс 11 сургалт зохион байгуулагдсан байна. Дотоод сургалтын төлөвлөгөөнд албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх дараах сургалтуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны зайн сургалтад 2023-2024 онд шинээр ажилд орсон албан хаагчдаас 10 албан хаагч 2. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад-4 албан хаагч 3. Дунд хугацааны давтан сургалтад-3 4. Ахлах түшмэлийн багц сургалтад-2 5. Эрхэлсэн түшмэлийн багц сургалтад-2 нийт 21 албан хаагчийг тус тус сургасан байна. Албан хаагчдыг ажлын байран дээр чадваржуулах 16 сургалт төлөвлөснөөс 10 сургалтыг амжилттай зохион байгуулсан. Үүнд: - Ярих ур чадвар техникийн сургалтад -15 албан хаагч - Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад нийт албан хаагч - Худалдан авах ажиллагааны АЗ сургалтыг 2 удаа зохион байгуулж, 21 албан хаагч - АТГ-тай хамтран эрсдэлээс ангид ажиллах хууль эрх зүйн тухай ойлголт өгөх сургалтыг байгууллагын Ёс зүйн дэд хороотой хамтран зохион байгуулж, нийт албан хаагчдыг хамруулсан. - MNS ISO/IEC 15189:2024 “Эрүүл мэндийн лаборатори-чанар, чадавхад тавих шаардлага” сургалт - ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны дотоод аудиторын сургалт	
--	--	--	--	--	--	--	--

						- Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх сургалтад нийт албан хаагчид - Прокурорын сургалтад ЧХГ, Тусгай зөвшөөрлийн шинжээчид - Байгууллагын Ёс зүйн дэд хороотой хамтран нийт албан хаагчдад танхим, цахим хэлбэрээр Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын талаар сургалт зохион байгуулсан. - Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт Төлөвлөгөөт бус сургалтууд: - Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга танилцуулах сургалтыг нийт албан хаагчдад танхимаар зохион байгуулсан. - Төрийн албаны зөвлөлийн 165 дугаар тогтоолын дагуу ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнтэй хамтран Монгол бичгийн сургалт танхим, цахим хэлбэрээр зохион байгуулж, 20 албан хаагчийг хамруулсан. - Авлигатай тэмцэх газартай хамтран Авлига, ашиг сонирхлоос ангид ажиллах, шинээр томилогдсон албан хаагчдад ХАСХОМ хэрхэн мэдүүлэх тухай сургалт 5 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж мэдээлэл өгсөн. - ТАХ-ийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн танилцуулга 2024.03.07-ны өдөр зохион байгуулсан. - Дижитал шилжилт, виртуал орчинд ажиллах нь сургалт - Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага сургалт - БНСУ-ын Төрийн албаны сонгон шалгаруулалтын ерөнхий тойм, онцлог - Төрийн албаны шинэтгэл ба цэгцрэх хөдөлгөөн, ТАХ-ийн цалин хөлс,	
--	--	--	--	--	--	---	--

						нийгмийн баталгаа зэрэг сургалтууд цахимаар хамрагдаж суралцсан. - МУ-ын Засгийн газар, ЦХХХЯ, ЭМЯ-наас зохион байгуулсан “Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” 3 өдрийн сургалт Гадаад сургалт: БНСУ-д зохион байгуулагдсан 8 төрлийн сургалтад Эм шинжлэх лабораторийн 6 албан хаагчийг ДЭМБ-ын санхүүжилтээр сургасан байна. Зохион байгуулагдсан сургалтууд: - 2024 introductory course for standard practice (GxP) - ICH GOOD CLINICAL PRACTICE E6 (R2) - 2024 introductory course for biologics development and manufacturing - 2024 introductory course for biologics development and manufacturing - Цар тахал болон бусад өвчний дэгдэлттэй тэмцэх Азийн оношлогоо вакцин эмчилгээний зохицуулагчдын удирдлагын уулзалт, хэлэлцүүлэг - 7th Trainig on Quality Control of biologicals in the Asia-Pacific Region - 2024 introductory course for standard practice (GxP) - ICH GOOD CLINICAL PRACTICE E6 (R2)	
14.	БСТ 1.7 Арга хэмжээ 1.14 Санхүүгийн төлөвлөлтийг оновчтой хийж, ил тод байдлыг хангаж ажиллана.	-	Шилэн дансанд байршуулсан мэдээлэл Төсөл хөтөлбөрийн санхүүжилт	2023 онд шилэн дансанд 12 мэдээлэл байршуулсан. ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр 2023 онд 9 төсөл хэрэгжүүлсэн.	Төсвийн төлөвлөлтийг үйл ажиллагаатай уялуулж, холбогдох мэдээлэл, тайланг тогтмол цаг хугацаанд нь ил тод байршуулсан байна.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, ил тод байдлыг хангах ажлын хүрээнд тайлант хугацаанд 63 удаагийн мэдээллийг shilendans.gov.mn цахим хуудаст байршуулсан. Засгийн газрын нээлттэй мэдээллийн сан shilen.gov.mn системд 23 бүлэг мэдээллийг оруулсан байна. Үүнд: - Шилэн данс цэсний 3 бүлгийн 158 мэдээлэл байршуулсан. /shilendans.gov.mn/	100

						- Байгууллагын мэдээллийн самбарт нийт 11 мэдээлэл боловсруулан байршуулсан. - 2024 оны батлагдсан төсвөөр төлөвлөгөө 109549200 гүйцэтгэл 1346156600 орсон нь нийт 250,6 сая төгрөгийн орлого давсан байна Мөн 2024 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 54,091,500 төгрөгийн санхүүжилттэй “Хүүхдийн хорт хавдрын дэлхийн платформ” санаачлагыг хэрэгжүүлэх хүрээнд эмийн хадгалалт, түгээлтийн суурь стандартуудыг боловсруулах төсөл хэрэгжсэн. 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 1,504,130,215.76 төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.	
15.	ЗГҮАХ 2.1.8 БСТ 1.8 Арга хэмжээ 1.15 Эмийн зохицуулалтын үйл ажиллагааны нэгдсэн цахим тогтолцоог бүрдүүлнэ.	13 сая (улсын төсөв)	Нэгдсэн цахим программ Цахим үйлчилгээний тоо	Үйл ажиллагаандаа Tzmoh.gov.mn Licemed.mohs.gov.mn EMongolia Heps.hdc.gov.mn Ereport ing Lims программ ашиглаж байна.	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй цахим программын уялдааг хангаж, нэгдсэн цахим тогтолцооны төслийг боловсруулсан байна.	1.Эмийн бүртгэлийн Лайсмед программд нийт 45 удаагийн шинэчлэл хөгжүүлэлтээр 88 талбар нэмсэн. Тус программ хангамжийг Гаалийн ерөнхий газар, Сангийн яамны төлбөрийн баримтын системтэй мэдээлэл солилцох ажил хийгдэж, хилээр орж ирж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг гаалийн мэдээллээс иргэдийн гарт очих хүртэлх мэдээлэл солилцож, эмийн үнэ, чанар, аюулгүй байдлын хяналтыг хийхээр ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд: - Гаалийн ерөнхий газрын бүрдүүлэлтийн хяналт шалгалтын газрын төлөөлөл болон бусад холбогдох гаалийн байцаагч нартай танхимаар уулзалт хийж, эмийн бүртгэл мэдээллийн Лайсмед программаас эмийн цуврал, тоо хэмжээг Гаалийн ерөнхий газрын цахим бүрдүүлэлтийн программд гэрээний хавсралтад заасан гаалийн бүрдүүлэлтийн мэдээллээс 36 төрлийн мэдээллийг эмийн бүртгэлийн	90

						Лайсмед программд авч мэдээлэл солилцож байна. - Импортын эмийн гаалиар орж ирсэн үнэ, зах зээлд борлуулагдаж байгаа үнийн мэдээллийг авах, эмийн үнийн шатлал бүр дэх нэмэгдлийн хэмжээг хянах зорилгоор Татварын ерөнхий газартай 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр ТЕГ-01/36 дугаартай хамтран ажиллах гэрээ, Гаалийн ерөнхий газартай 2024 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн ГЕГ15/24 дугаартай хамтран ажиллах гэрээг тус тус байгуулсан. - 2024 оны 01/81 дугаар албан бичгээр төрийн мэдээллийн нэгдсэн "Хур" сүлжээнд холбох хүсэлт хүргүүлэн Лайсмед программын эмийн бүртгэлийн серверт "OPENVPN" холболт хийж, И-монголиа программтай холболт хийгдсэн. 2024 оны 01/493 дугаар албан бичгээр Гаалийн ерөнхий газрын программтай холболт хийх хүсэлтийг Үндэсний дата төвд хүргүүлсэн. - Тагнуулын ерөнхий газрын МАБГ-аас Ай Пи хаяг авч 4 дүгээр сарын 30-ны өдрөөс 5 дугаар сарын 02-ны өдрүүдэд Лайсмед программын серверийг Мэдээллийн аюулгүй байдлын газрын серверт холбох физик холболтыг хийж, Гаалийн ерөнхий газрын программтай 36 төрлийн мэдээлэл солилцож байна. - Лайсмед программын эмийн мэдээллийг лавлах сервис, эмийн зураг баркодоор хайх сервис, эмийн хэрэглэх заавар баркодоор хайх сервисийг төрийн мэдээлэл солилцооны Хур системд нээлттэй байршуулсан. Ингэснээр эмийн мэдээллийг эмийн	
--	--	--	--	--	--	--	--

						сангийн программ хөгжүүлэгч байгууллагуудад хүртээмжтэй ажиллах боломж бүрдүүлсэн. - Мэдээлэл солилцохтой холбоотой хийх өөрчлөлтийг тодорхойлж, хөгжүүлэлт хийхээр гаалийн бүрдүүлэлт системийн ажлын байрны зураглал болон Моносфарм Трейд ХХК, Мөнхийн тун ХХК-ний үйл ажиллагаандаа хэрэглэдэг системтэй тус тус танилцаж, гаальтай мэдээлэл солилцох сервис гаргаж, программын хөгжүүлэлтийг хийсэн. - Эмийн үнийн өсөлтөд олон нийтээс тавих хяналтыг бий болгох зорилгоор ТЕГ, ГТСМТТ-тэй хамтран хангамжийн шатлал бүрд эмийн нэр төрөл, үнэ, цувралын мэдээлэл солилцох байгууллага хоорондын цахим мэдээллийн нэгдсэн программ хөгжүүлэлт үе шаттай хийгдэж, гааль, татвартай мэдээлэл солилцох сервис гаргахаар хамтран ажиллаж байна. Серверийн ашиглах эрхийг шилжүүлэн авч гэрээ хийсний дараа өгөгдлийн сангийн нууц үгийг шинэчилнэ. - Лайсмед программ хэрэглэгчид нууц үгээ улирал тутам сольж байхаар кодын шинэчлэл хийж, 2024 оны 8 дугаар сарын 31-ний өдөр SSL сертификат тохируулга Licemed.mohs.mn домэйн хаяг дээр хийсэн. - Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 50 дугаар зүйлийн 50.1.22 дах хэсэгт эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх, үйлдвэрлэхээс устгах хүртэлх үе шатыг хамруулсан нэгдсэн цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, аюулгүй байдал, нууцлалыг хангах, мэдээлэл солилцох эрхийг Эм,	
--	--	--	--	--	--	--	--

						эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр туссан. Энэ зохицуулалтын хүрээнд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын А/176 дугаар тушаалаар “Кибер аюулгүй байдлыг хангах” дотоод журам батлагдсан. 2. Дийг Ай Ти ХХК-тай “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын суурь системийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах” ЭЭХХЗГ/03/28 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын нэгдсэн системийн ажлын даалгавар боловсруулж, Эрүүл мэндийн яаманд цахимаар хүргүүлсэн. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Мэдээлэл технологийн алба ажлын даалгаврын дагуу эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалт, хяналтын цахим тогтолцоог сайжруулах программын хөгжүүлэлтийг эхлүүлэн хамтран ажиллаж байна. 3. Эмийн мэдээллийг төрийн үйлчилгээний цахим систем И-Монголиа цахим системтэй холбох ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд: - И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газарт Вакцины бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн үйл ажиллагаа болон Биобэлдмэлийн бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн үйл ажиллагааг цахимжуулах хүсэлтийг хүргүүлж, 5 дугаар сарын 03-ны өдрөөс үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн. - Жоргүй олгох эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны хүсэлт хүлээн авах, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг И-Монголиа цахим	
--	--	--	--	--	--	--	--

						системээр 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлж, 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар 52 хүсэлт хүлээн авсан байна. - Эмийн зар сурталчилгааны зөвшөөрлийн онцлог нь агуулгыг засаж олгогддог зөвшөөрлийн үйл ажиллагаа тул зар сурталчилгааны зөвшөөрлийн агуулгыг И-Монголиа цахим системээр зөвхөн PDF файл хүсэлт хүлээн авдаг байсныг word файлаар хүлээн авдаг болсон. - “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-д эмнэлгийн хэрэгслийн зар сурталчилгааны зөвшөөрөл олгогдох болсон тул цахим систем дэх зөвшөөрлийн нэрийг шинэчлэх хүсэлтийг 01/1545 дугаар албан бичгээр хүргүүлж, нэрийг өөрчилсөн. - AR-Монголиа хиймэл оюун ухааны апп-тай хамтран 100 эмийн хэрэглэх зааварт хяналт хийж, иргэд эмийн хэрэглэх зааврыг И-Монголиа цахим системээр харахаар холбосон.	
Зорилт 2. Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн ил тод байдлыг хангаж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмжид нөөцийн мэдээний санг ашиглан дүн шинжилгээ хийнэ.							
16.	БСТ 2.1 Арга хэмжээ 2.1. Ерөнхий гэрээгээр худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг нэмэгдүүлнэ.	54 сая (улсын төсөв)	Цахим дэлгүүрт нэмэгдсэн эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрөл	Цахим дэлгүүрт 143 нэрийн эм, эмнэлгийн хэрэгсэл байршсан.	Цахим дэлгүүрт 15-аас дээш нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нэмсэн байна.	Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн тайлангийн үнэлгээнээс гарсан үр дүнгийн дагуу ерөнхий гэрээний цахим дэлгүүрт байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг нэмэгдүүлэх 18 нэрийн эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 11 дүгээр сарын 22-ны 01/2043 дугаар албан бичгээр төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн.	100
17.	БСТ 2.2 Арга хэмжээ 2.2. Эм, эмнэлгийн хэрэгслийн		Хангамжийн нэгдсэн цахим мэдээний сан	Licemed.mohs.gov.mn программд	Эмийн үнэ, хангамж, нөөцийн мэдээлэл солилцох программын	Эмийн бүртгэлийн Лайсмед программ хангамжийг Гаалийн ерөнхий газар, Сангийн яамны төлбөрийн баримтын системтэй мэдээлэл солилцох ажил хийгдэж, хилээр орж	90

	хангамжийн нэгдсэн цахим мэдээний сан бүрдүүлж, эмийн үнийн ил тод байдлыг хангана.			ЭХНБ-уудын лиценз олгоход мэдүүлсэн эмийн үнэ, тоо хэмжээний мэдээлэл	хөгжүүлэлтийг эхлүүлсэн байна.	ирж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг гаалийн мэдээллээс иргэдийн гарт очих хүртэлх мэдээлэл солилцож, эмийн үнэ, чанар, аюулгүй байдлын хяналтыг хийхээр ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд: - Тагнуулын ерөнхий газрын МАБГ-аас Ай Пи хаяг авч 4 дүгээр сарын 30-ны өдрөөс 5 дугаар сарын 02-ны өдрүүдэд "Лайсмед" программын серверийг Мэдээллийн аюулгүй байдлын газрын серверт холбох физик холболтыг хийж, ГЕГ-тай 2024 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн ГЕГ15/24 дугаартай хамтран ажиллах гэрээ байгуулсан. - Гаалийн ерөнхий газрын бүрдүүлэлтийн хяналт шалгалтын газрын төлөөлөл болон бусад холбогдох гаалийн байцаагч нартай хамтран хөгжүүлэлт хийж, эмийн бүртгэл мэдээллийн лэйсмед программаас эмийн цуврал, тоо хэмжээг гаалийн ерөнхий газрын цахим бүрдүүлэлтийн програмд, Гаалийн ерөнхий газрын цахим программаас гэрээний хавсралтад заасан гаалийн бүрдүүлэлтийн мэдээллээс 37 төрлийн мэдээллийг эмийн бүртгэлийн лэйсмед программд авч, эмийн импортыг бүрэн цахимжуулсан. - Импортын эмийн гаалиар орж ирсэн үнэ, зах зээлд борлуулагдаж байгаа үнийн мэдээллийг авах, эмийн үнийн шатлал бүр дэх нэмэгдлийн хэмжээг хянах зорилгоор Татварын ерөнхий газартай 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр ТЕГ-01/36 дугаартай хамтран ажиллах гэрээ, Гаалийн ерөнхий газартай 2024 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн ГЕГ15/24 дугаартай хамтран ажиллах гэрээг тус тус байгуулсан. Цахим системийн хөгжүүлэлтийг 2024 оны 11	
--	---	--	--	---	--------------------------------	---	--

						дүгээр сарын 25-ны өдрийн Эрүүл мэндийн сайдын зөвлөлийн хуралд танилцуулж, Эрүүл мэндийн яамнаас ТЕГ-т 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр дараагийн шатны хөгжүүлэлтийг хамтран хэрэгжүүлэх 2/4985 дугаар албан бичиг хүргүүлсэн. - Эмийн зах зээлийн дараах чанар аюулгүй байдлын хяналтыг цувралын дугаараар мөшгөх тогтолцоо бий болох зорилгоор эм, эмнэлгийн хэрэгсэлийг худалдан борлуулахад Цахим төлбөрийн баримтын систем "POS API 3.0"-д цувралын дугаараар бүртгэгдэх боломжийг бүрдүүлж, И-баримтын загварт цувралын дугаар хэвлэх. Ингэснээр иргэний эмийн сангаас худалдан авсан эм дээрх цувралын дугаар И-баримтын цувралын дугаартай ижил болж, хууль бус болон хуурамч эмийн эргэлтийг илрүүлэх, таслан зогсоох ач холбогдолтой юм. - Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн удирдлага, үнийн өсөлтөд хяналтын тогтолцоо бүрдүүлэх зорилгоор Цахим төлбөрийн баримтын системээс эм хангамжийн байгууллагын борлуулсан тоо хэмжээ, бөөний үнэ, жижиглэнгийн үнийн мэдээллийг солилцох дээрх мэдээллийг дашборд хэлбэрээр Засгийн газрын "Их өгөгдлийн (big data) сан"-д тогтмол нийлүүлэх зэрэг болно. - Төрийн мэдээллийн нэгдсэн "Хур" сүлжээнд холбох хүсэлт 2024 оны 01/81 дугаар албан бичгээр хүргүүлж, "Лайсмед" эмийн бүртгэлийн серверт "OPENVPN" холбогдож И-монголиа программтай холболт хийгдсэн. 2024 оны 01/493 дугаар албан бичгээр Гаалийн ерөнхий газрын программтай холболт хийх хүсэлтийг Үндэсний дата төвд хүргүүлсэн.	
--	--	--	--	--	--	---	--

						- Лайсмед программын эмийн мэдээллийг лавлах сервис, эмийн зураг баркодоор хайх сервис, эмийн хэрэглэх заавар баркодоор хайх сервисийг төрийн мэдээлэл солилцооны Хур системд нээлттэй байршуулсан нь эмийн мэдээллийг эмийн сангийн программ хөгжүүлэгч байгууллагуудад хүртээмжтэй ажиллах боломж бүрдүүлсэн.	
18.	Алсын хараа 2050 2.2.5 Арга хэмжээ 2.3. Эрт илрүүлэгт шаардагдах лабораторийн урвалж бодис, оношлуур, эмнэлгийн хэрэгслийн нөөц, чанар аюулгүй байдалд тандалт хийж, хяналт тавин ажиллана.	-	Нөөцийн мэдээллийн тоо Тандалтын тоо Хяналт тавьсан байгууллагын тоо	Нөөцийн мэдээллийг 26 ханган нийлүүлэх байгууллагаас 7 хоног бүр нийт 42 удаа авсан. 17 АНЭ, БОЭТ-ийн эрт илрүүлэгт шаардагдах лабораторийн урвалж, бодис, оношлуур, эмнэлгийн хэрэгслийн нөөц, чанар аюулгүй байдалд давхардсан тоогоор 20 удаа хяналт тавьсан.	Эрт илрүүлэгт шаардагдах лабораторийн урвалж бодис, оношлуур, эмнэлгийн хэрэгслийн нөөц, чанар аюулгүй байдалд тандалт хийх ажлын хэсгийг байгуулж, хяналт хийн зөрчлийг арилгуулах, холбогдох зохицуулалтын арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.	Эрт илрүүлэгт хэрэглэгдэх урвалж, оношлуур, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээллийг 7 хоног бүр 20 ханган нийлүүлэх байгууллага, 54 эрүүл мэндийн байгууллагаас нийт 36 удаа авч улсын хэмжээний нөөцийн нэгдсэн мэдээллийг зах зээлд болон эрүүл мэндийн байгууллагуудын түвшинд гаргаж, удирдлага, Эрүүл мэндийн яам, эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж ажилласан. Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/379 дүгээр тушаалын дагуу агентлагийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/03 дугаар тушаалаар “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд шаардагдах лабораторийн урвалж, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн хангамжийг зохицуулах, ашиглалт, чанар аюулгүй байдалд хяналт, зохицуулалт хийх, эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангах, зах зээлийн үнийн судалгаа гаргах” ажлын хэсэг байгуулагдсан. Эрт илрүүлэг хийж буй эрүүл мэндийн байгууллагад хэрэглэж буй лабораторийн урвалж бодис, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, дагалдах хэрэгслийн нөөцийн мэдээлэл авах асуумж боловсруулж, хяналт, үнэлгээ хийх удирдамжийг 02 дугаар сарын 21-ний өдөр батлуулсан. Хяналт, үнэлгээнд Эрүүл мэндийн яамны харьяа 3, бусад яамны харьяа 1, нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 8,	100

						орон нутгийн харьяа 18, хувийн хэвшлийн 30 буюу нийт 60 эрүүл мэндийн байгууллага хамрагдсан бөгөөд хяналт, үнэлгээний явцад цуглуулсан мэдээллийг нэгтгэж, тайланг Эрүүл мэндийн яамны ажлын хэсэгт танилцуулсан.	
Зорилт 3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй байдлыг хангана.							
19.	БСТ 3.1 Арга хэмжээ 3.1 Эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийнэ.	40 сая (улсын төсөв)	Шалгалт тохируулга хийсэн тоног төхөөрөмжийн тоо	Шалгалт тохируулга хийсэн тоног төхөөрөмжийн тоо-1912	Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 1920 эмнэлгийн тоног төхөөрөмжийг шалгалт тохируулгад хамруулсан байна.	Төрийн өмчийн эрүүл мэнд байгууллагаас шалгалт тохируулга хийлгэх хэрэгцээ шаардлагын судалгаанд үндэслэн “Эрүүл мэндийн байгууллага ашиглагдаж эмнэлгийн тоног төхөөрөмжид 2024 онд шалгалт тохируулга хийх хуваарь” болон “Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх удирдамж”-ийг боловсруулж, 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр батлуулсан. Батлагдсан хуваарь болон ирүүлсэн албан хүсэлтийн дагуу Эрүүл мэндийн яамны харьяа 4, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 9, орон нутгийн 2, бусад яамны харьяа 1, сумын эрүүл мэндийн төв 6, Өрхийн эрүүл мэндийн төв 80, хувийн хэвшлийн 112 нийт 214 эрүүл мэндийн байгууллагын 2435 эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийснээс 88.7% тэнцсэн байна. Нийт 214 эрүүл мэндийн байгууллагатай шалгалт тохируулгын гэрээ байгуулсан. Мөн шалгалт тохируулгад хамрагдсан 2435 эмнэлгийн тоног төхөөрөмж тус бүрээр шалгалт тохируулгын үр дүнг боловсруулж, үр дүнгийн нэгтгэлийн хамт холбогдох эрүүл мэндийн байгууллагад албан бичгээр тус тус хүргүүлсэн.	100
20.	БСТ 3.2 Арга хэмжээ 3.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжтэй холбоотой үйл ажиллагааг цахимжуулна.	-	Цахим гарын авлага Гарын авлагын хандалтын тоо	Урьдчилсан дүгнэлт гаргах, шалгалт тохируулга хийлгэх, мэдээллийн сангийн хэрэглэгчийн эрх нээх	Урьдчилсан дүгнэлт гаргах, шалгалт тохируулга хийлгэх, мэдээллийн сангийн хэрэглэгчийн эрх нээх илгээх, шийдвэрлэлтийн явцтай хэрхэн танилцах талаар	Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл, хяналтын систем буюу les.e-business.mn цахим программаар дамжуулан урьдчилсан дүгнэлт гаргах, шалгалт тохируулга хийлгэх, мэдээллийн сангийн хэрэглэгчийн эрх нээх хүсэлт илгээх, шийдвэрлэлтийн явцтай хэрхэн танилцах талаар хэрэглэгчид зориулсан цахим гарын авлагыг боловсруулж, байгууллагын цахим хуудсанд 2024 оны 5 дугаар сарын 30-ны	100

				хүсэлтийг хүсэлтийг E- mongolia төрийн цахим системээр хүлээн авах программ хангамж бэлэн болсон.	хэрэглэгчид зориулсан цахим гарын авлагыг боловсруулж, байгууллагын цахим хуудсанд байршуулж, хүсэлтийг E-mongolia төрийн цахим системээр хүлээн авдаг болсон байна.	өдөр байршуулсан. Байгууллагын цахим хуудсаар дамжуулан тус гарын авлагатай танилцахаар нийт 641 удаа хандсан байна. Мөн тус системээр Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хийлгэх хүсэлт 91, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгийн төлөвлөлтийн системд эрх авах хүсэлт 39, Техникийн комиссын урьдчилсан дүгнэлт хийлгэх хүсэлт 75 буюу нийт 205 хүсэлт ирүүлсэн бөгөөд үүний дагуу хүсэлтийн дагуу шаардлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлж, e- business.mn цахим программ болон холбогдох албан бичгээр хариуг хүргүүлсэн.	
21.	Арга хэмжээ 3.3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын лабораторийн итгэмжлэл авах бэлтгэл ажлыг хангана.	-	Боловсруулсан чанарын гарын авлага	-	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын лабораторийн итгэмжлэл авах бэлтгэл ажлыг хангаж, чанарын гарын авлагыг боловсруулсан байна.	MNS ISO/IEC 17025:2018 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага” стандарт, Стандарт, хэмжил зүйн газраас ирэх MNAS AF04 “Сорилтын лабораторийг итгэмжлүүлэхээр хүсэлт гаргах өргөдөл” баримт бичгийн шаардлагын дагуу Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх лабораторийн чанар гарын авлагын зорилго, хамрах хүрээ, нэр томьёо, тодорхойлолт, ерөнхий шаардлага, нөөцөд тавих шаардлага, үйл явцын шаардлагын хэсэг болон тус гарын авлагыг дагалдан гаргах үйлчлүүлэгчээс гарсан санал гомдлыг барагдуулах журам, Дотоод хяналтын журам, Лабораторид тоног төхөөрөмж хүлээн авах, шалгах, олгох журмын төслийг боловсруулсан.	70
22.	Арга хэмжээ 3.4 Эрүүл мэндийн салбарт нийлүүлэгдэж буй эмнэлгийн тоног төхөөрөмжид хяналт тавьж, “Урьдчилсан дүгнэлт” гаргана.	-	Урьдчилсан дүгнэлт гаргуулах албан хүсэлтийн шийдвэрлэлт ийн хувь	Урьдчилсан дүгнэлт гаргуулах албан хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь - 100	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэх байгууллагаас урьдчилсан дүгнэлт гаргуулах албан хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь 95-иас дээш байна.	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэх 16 байгууллагын 83 албан хүсэлтийн дагуу захиалагч байгууллагатай хийсэн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, тоног төхөөрөмжийн холбогдох баримт бичигт үндэслэн 243 (давхардсан тоогоор) нэр төрлийн 7339 эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн загвар, техникийн үзүүлэлт, бүрэн бүтэн байдлыг хангаж буй эсэхийг газар дээр нь Комиссын гишүүд очин шалгаж, нийт 83	100

